

МЭДЭЭЛЭЛ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ТӨВ

ТӨВИЙН 24 ЦАГААР ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭДЭГ АЛБА ХААГЧДЫН ХООЛ, ХҮНС
НИЙЛҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хянасан:

Захиргааны Удирдлагын хэлтсийн
Санхүү, аж ахуйн тасгийн дарга,
цагдаагийн дэд хурандаа

 П.Доржготов

Боловсруулсан:

Захиргааны Удирдлагын хэлтсийн
Санхүү, аж ахуйн тасгийн барилгын
ашиглалт хариуцсан инженер,
аж ахуйн офицер,
цагдаагийн ахлах дэслэгч

 М.Батцэнгэл

ГАРЧИГ

| | |
|---|---|
| ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ | 3 |
| Нэг. Барааны тодорхойлолт: | 3 |
| Хоёр. Орлогч нь дор дурьдсан үндсэн мэргэжилийн ажилтантай байна..... | 3 |
| Гурав. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь | 4 |

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нэг. Барааны тодорхойлолт:

Хоолны төлбөр, тооцоо

1. Өдөрт ээлжийн 22-27, жилд 8030-9855 алба хаагч тогтмол хооллоно.
2. Ээлжийн алба хаагчдын өдрийн хоолны үнэ 1 хүний 16000 төгрөг байна.
3. Ээлжийн алба хаагчдад хоолоор үйлчилсний дараа өдрийн 8 цагаар ажилладаг алба хаагчдад хөнгөлттэй үнэтэй хоолоор үйлчилнэ.

Хоолны нэр, төрөл

1. 1 дүгээр хоол /Үхэр, хонь болон бусад төрлийн сайн чанарын мах, гарал үүсэл, шинжилгээний бичигтэй байх/
2. 2 дугаар хоол /Үхэр, хонь болон бусад төрлийн сайн чанарын мах, гарал үүсэл, шинжилгээний бичигтэй байх/
3. Зууш салат, /Төрөл бүрийн муудаж, амт чанараа алдаагүй хүнсний ногоо, хүнсний материал, шинжилгээний бичигтэй байх/
4. Бусад жижиглэнгийн хоол /Төрөл бүрийн муудаж, амт чанараа алдаагүй хүнсний ногоо, хүнсний материал, шинжилгээний бичигтэй байх/
5. Цай болон бусад шингэн хүнс /Сүү болон бусад шингэн хүнсний материал нь цэвэр, шинжилгээний бичигтэй/
6. Хоол хүнс нь шаардлагатай илчлэгийн хэмжээнд байна.

Бусад

1. Ажлын цаг нь өдөр бүр 08:30-16:00 цагийн хооронд байна.
2. Алба хаагчдын захиалгаар өглөөний цай, хөнгөн зуушаар үйлчилнэ.
3. Гүйцэтгэгч талын байршил нь захиалагч байгууллагатай ойрхон байвал сайн.
4. Онцгой нөхцөл байдал үүссэн үед уртасгасан цагаар болон баяр, амралтын өдрүүдээр ажиллах боломжтой байна.
5. Гүйцэтгэгч хоолыг бэлэн болгож ирнэ. Тодорхой бага хэмжээний хоолыг тус байгууллагын цайны газарт хийх ба гарсан зардлыг гүйцэтгэгч тал хариуцна.
6. Цайны газар нь захиалагч байгууллагын 5 давхарт байрлана.
7. Тогооч, бэлтгэгч нь 6 сар тутамд эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдана.

Хоёр. Оролцогч нь дор дурдсан үндсэн мэргэжлийн ажилтантай байна.

| Албан тушаал | Хүний тоо | Ажлын туршлага | мэргэжил |
|------------------|-----------|-----------------------------|----------|
| Тогооч | 1 | 1-ээс доошгүй жил ажилласан | тогооч |
| Бэлтгэгч, тогооч | 1 | 1-ээс доошгүй жил ажилласан | |

1. Стандарт: Хоол хүнс нь эрүүл ахуй, аюулгүй байдлын чанар, стандартын шаардлагад нийцсэн байна.
2. Баглаа, боодол: Үйлдвэрийн сав баглаа, боодолтой байх, ууталж савласан байх.
3. Бараа хүргэх газар: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 хороо, Самбуугийн гудамж, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, 5-р давхар

Гурав. Барааны жагсаалт ба бараа нийлүүлэлтийн хуваарь

| Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж |
|---|--|------------|-------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын өдрийн хоол | Төрөл бүрийн 1, 2 дугаар хоол, зууш, цай | 8030-9855 | ширхэг |

ooOoo